



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/337

Мандалговь

Гамшгийн эрсдэлийг бууруулах
зөвлөл байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.5 дахь хэсэг 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.12 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303-р тогтоолоор баталсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Сум, баг, аж ахуй нэгж, байгууллагад сайн дурын бүлэг, хэсэг байгуулж, "Бэлэн бай" сургалтын багцыг иргэд, олон нийтэд үе шаттайгаар зохион байгуулж үүрэг чиглэл удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (Я. Алтанхундага)-д үүрэг болгосугай.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг зөвлөлийн гишүүдэд, авч хэрэгжүүлж байгаа ажлын талаарх мэдээллийг тухай бүр танилцуулж ажиллахыг Зөвлөлд даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж. МӨНХЧУЛУУН

480010092

Аймгийн Засаг даргын 2018 оны 07 дугаар
сарын 25-ны өдрийн 733 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: - Аймгийн засаг дарга
- Орлогч дарга: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Аймгийн Онцгой байдлын газрын дарга
- Гишүүд: - Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга
- Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга
- Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дарга
- Ус цаг, уур орчны шинжилгээний газрын дарга
- Цэргийн штабын дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Цагдаагийн газрын дарга
- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга
- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга
- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Хүнс хөдөө, аж ахуйн газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Гэр, бүл хүүхэд хөгжлийн газрын дарга
- Авто тээврийн төвийн дарга
- МУЗН-ийн салбарын дарга
- Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын салбарын дарга
- Орон нутгийн АРД ТВ
- Нарийн бичгийн дарга: - Онцгой байдлын газрын орлогч
- Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны 07 дугаар
сарын 25-ны өдрийн дугаар
захирамжийн 2 дугар хавсралт

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Гамшгийн эрсдлийг бууруулах орон нутгийн зөвлөл / цаашид "орон нутгийн зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Орон нутгийн зөвлөл нь гамшгаас хамгаалах болон бусад холбогдох хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2018 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам"-ыг удирдлага болгож, үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Орон нутгийн зөвлөлийг аймгийн Засаг дарга тэргүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой байдлын газрын дарга орлоно.

2.2. Орон нутгийн зөвлөл Ажлын албатай байна. Ажлын албыг аймгийн Онцгой байдлын газрын дарга удирдана.

2.3. Аймгийн газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах байнгын ажиллагаатай зөвлөл нь орон нутгийн зөвлөлийн дэд зөвлөл байна.

2.4. Аймгийн онцгой комисс, орон нутгийн гамшгаас хамгаалах албад нь чиг үүргийн хүрээнд орон нутгийн зөвлөлтэй үйл ажиллагаагаа уялдуулж ажиллана.

Гурав. Орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх

3.1. Орон нутгийн зөвлөл нь гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хамаарах эрхийг хэрэгжүүлнэ.

3.2. Орон нутгийн зөвлөлийн гишүүн дараах эрхтэй байна:

3.2.1. шаардлагатай тохиолдолд орон нутгийн зөвлөлийн ээлжит бус хуралдааныг хуралдуулах саналыг орон нутгийн зөвлөлийн даргад танилцуулах.

3.2.2. гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаа үндэсний болон орон нутгийн зөвлөлөөс гарсан зөвлөмжийн хэрэгжилтэд шаардагдах судалгаа, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага албан тушаалтнаас гаргуулан авах,

3.2.3. гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр эрхэлсэн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, салбар хоорондын зохицуулалтыг хангах асуудлыг орон нутгийн зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний зөвлөл / цаашид үндэсний зөвлөл гэх/-ийн хуралдаанд санал хүргүүлэх,

3.2.4 Орон нутагт гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр бодлогын зөвлөмж гаргах, нутгийн төрийн захиргааны байгууллагад чиглэл өгөх,

3.2.5 Орон нутгийн зөвлөлийг төлөөлөн олон улс, улс, орон нутгийн чанартай хурал, зөвлөгөөн, бусад арга хэмжээнд оролцох.

3.3. Орон нутгийн зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй байна:

3.3.1. Гамшгийн эрсдлийг бууруулах эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг орон нутагт хангах, хэрэгжүүлсэн ажлаа холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах, шаардлагатай тохиолдолд үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлэх;

3.3.2. гамшгийн эрсдлийг бууруулахтай холбоотой бодлогын зөвлөмж боловсруулах, бусад гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж салбар дундын зохицуулалтыг хангах;

3.3.3. Үндэсний болон орон нутгийн зөвлөлөөс гарсан шийдвэр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх

3.3.4. Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг тухайн жилийн төсөвт тусгах санал боловсруулах.

Дөрөв: Орон нутгийн зөвлөлийн хуралдаан

4.1. Орон нутгийн зөвлөлийн ажиллах үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг орон нутгийн зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.

4.2. Хуралдааны дэгийг орон нутгийн зөвлөл батална. Орон нутгийн зөвлөлийн хуралдааны шийдвэр нь зөвлөмж байна.

4.3. Орон нутгийн зөвлөлийн ээлжит хуралдааныг жилд .. /1/-оос доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

4.4. Ээлжит хуралдааны товч хуралдаан болохоос 10-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хурлын материалыг тараасан байна.

4.5. Орон нутгийн зөвлөлийн хуралдааныг нийт гишүүдийн 51-ээс дээш хувийн ирцтэйгээр хуралдуулна. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхийн саналаар, санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

4.6. Орон нутгийн зөвлөлийн даргын шийдвэрээр орон нутгийн зөвлөлийн хуралдаанд холбогдох эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллөөс оролцуулж болно.

Тав: Орон нутгийн зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагаа

5.1. Орон нутгийн зөвлөлийн ажлын алба дараах үйл ажиллагааг явуулна:

5.1.1. хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааныг зохион байгуулах,

5.1.2. орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад гишүүдээс гадна бусад холбогдох талуудыг татан оролцуулах, хяналт тавих,

5.1.3. орон нутгийн зөвлөлд ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэх;

5.1.4. хуралдааны шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх, биелэлтийг гаргуулах,

5.1.5. үндэсний болон орон нутгийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа ажил, түүний явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах;

5.1.6. үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичиг, мэдээ мэдээлэл, судалгааг холбогдох байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулан авах,

5.1.7. эрх, үүргээ хэрэгжүүлээгүй орон нутгийн зөвлөлийн гишүүд, холбогдох талуудад хариуцлага хүлээлгэх саналыг орон нутгийн зөвлөлийн даргад танилцуулах

5.1.8. орон нутгийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, жилийн үйл ажиллагааны тайланг үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлэх,

5.1.9. орон нутгийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нар ажлын албаны үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад хамтран ажиллах.

Зургаа: Бусад

6.1. Орон нутгийн зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

6.2. Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг тухайн жилийн орон нутгийн төсөв, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.3-т заасны дагуу бүрдүүлсэн гамшгийн эрсдлийг бууруулах сан болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.